

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 6

1. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх тухай асуудал

4 – 6

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 03-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Оюун-Эрдэнэ, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Ж.Баярмаа;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа, Ч.Лодойсамбуу;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Ч.Ундрэм, Ө.Шижир.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 1.Засгийн газраас 2026 оны 07 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 4

Бүгд: 19

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Засгийн газраас 2026 оны 07 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 4

Бүгд: 19

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Засгийн газраас 2026 оны 07 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 4

Бүгд: 19

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 10 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН

БАЙНГЫН ХОРООНЫ

ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН

ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
09 цаг 57 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 07 дугаар сарын 03-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаа эхлүүлье.

Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026-ны оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Та бүхэнд өнөөдрийн ирцийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл, Жигжидийн Батжаргал, Амгаланбаатарын Ганбаатар, Сархадын Зулпхар, Бөхчулууны Пүрэвдорж, Одонгийн Цогтгэрэл, Аюушийн Ариунзаяа, Баярмагнайн Баярбаатар, Лувсаннямын Гантөмөр, Лхагваагийн Мөнхбаатар, Цэвэгдоржийн Туваан, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Бат-Эрдэнэ, Сандагийн Бямбацогт, Болдын Жавхлан, Бадрахын Найдалаа, Ням-Осорын Учрал, Доржзовдын Энхтуяа нарын 18 гишүүд хуралдаандаа ирсэн. Хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Байнгын хорооны хуралдааны ирцийг Та бүхэнд танилцууллаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр нэг л асуудал байна.

Улсын Их Хурлын 2026 оны ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл хүлээлгэж чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл, өргөн мэдүүлсний зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй.

1.Засгийн газар 2026 оны 07 сарын 02-ны өдрийн өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлэн болсон байна. Санал хураалт. /алх цохив/

78.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газар 2026 оны 07 сарын 02-ны өдрийн өргөн мэдүүлсэн Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

78.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Засгийн газар 2026 оны 07 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

78.9 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 10 цаг 00 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД